

ТӨСӨЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дугаар зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Монгол Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны . . дугаар сарын . . -ны өдрийн хуралдааны . . / . . дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

НЭГ.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.6 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2.4.Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

№	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Гадаадын барааг чөлөөт бүсэд оруулах		
	Гадаадын барааг хилийн чанадаас оруулах	770	шаардахгүй
	Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулсан барааг оруулах	771	551-554
2	Монголын барааг чөлөөт бүсэд оруулах		
	Монголын барааг хилийн чанадаас оруулах	772	100, 101, 120, 141-144, 150
	Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс оруулах	773	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат бүсээс чөлөөт бүсэд оруулах		
	Барааг гаалийн баталгаат агуулахаас оруулах	774	700, 703, 705, 706, 707, 709
	Барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас оруулах	775	720, 722, 724
	Барааг гаалийн баталгаат үйлдвэрийн газраас оруулах	776	710, 712, 713, 715
4	Чөлөөт бүсээс чөлөөт бүсэд оруулах	777	770-776, 778
5	Гаалийн бусад хяналтаас чөлөөт бүсэд оруулах	778	шаардахгүй
6	Чөлөөт бүсэд оруулсан барааг чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт худалдах, зарцуулах	779	770-778

2.6.Чөлөөт бүсэд оруулсан, эсхүл тэнд үйлдвэрлэсэн барааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөр чөлөөт бүсэд оруулахад мөн тухайн чөлөөт бүс дотор үйл ажиллагаа

явуулж байгаа өөр этгээдэд барааг шилжүүлэхэд гаалийн бүрдүүлэлтийн горимын 777 кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ.

ХОЁР.Энэхүү журамд дор дурдсан агуулга бүхий 3.21, 4.4.10, 5.1.5 дахь заалтыг нэмсүгэй:

3.21.Чөлөөт бүсэд худалдсан барааг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож нэгтгэн, дараа сарын 05-ны өдрийн дотор санхүүгийн баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлтийн горимын 779 кодоор гаалийн байгууллагад мэдүүлж, бүрдүүлэлт хийлгэнэ.

4.4.10.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь гаалийн байгууллагатай гаалийн онлайн сүлжээнд холбогдсон байхаас гадна чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад тоо, хэмжээний хязгаарлалт тогтоосон барааг тогтоосон тоо, хэмжээнээс хэтрүүлэн худалдахгүй.

5.1.5.Зорчигч чөлөөт бүсээс Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2.3.1-д¹ заасан барааг хоногт нэг удаа, тухайн сард нийтдээ таваас илүүгүй удаа гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн нутаг дэвсгэрт оруулж болно.

ГУРАВ.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Даваасүрэн/, тушаалыг олон нийтэд сурталчлан таниулахыг Хуулийн хэлтэс /Ч.Тамираа/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

¹ 2.3.1.Архины зүйлс 2 литр, дарс 2 литр, шар айраг 3 литр, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй.